

## ГУРВАН ТАЛЫН НЭГДЭЛТЭЙ АЗИ ХИЙГЭЭД ХОЁР ТАЛЫН НЭГДЭЛТЭЙ СОЛОНГОС

*Н.Сарантуяа\**

Өнөөгийн Азийг судлагч зарим эрдэмтэд Азийг нэгдмэл бус, гурван тал хэмээн үзэж байна. Ингэхдээ үсрэнгүй хөгжиж байгаа Азийн орнууд болох Энэтхэг, Хятад, Япон, Өмнөд Солонгос болон Тайвань, Индонези зэрэг улсуудыг нэг дэх томоохон хэсэгт багтаан үзэж байна. Харьцангуй буурай хөгжилтэй хэмээн тодорхойлж байгаа араб-лалын шашинт ертөнцийг Ойрхи Дорнод, Дундад Ази хэмээн хоёр, гуравдугаар хэсэг болгон үзсэн байна.

Бидний хувьд энэ ангиллын нэг дэхи ангилалтай үндсэндээ санаа нийлж буй, харин нөгөө хоёр Азийн хувьд гэвэл араб-лалын ертөнцийг бүхэлд нь нэг хэсэг болгон үзэж болох юм. Харин Монгол, БНАСАУ, Лаос, Вьетнам зэрэг хуучин социалист тогтолцоотой улс орнуудад хөгжлийн бодит бололцоо, хэтийн төлөв ихээхэн хуримтлагдсан байгааг онцлон тэмдэглэж нэгэн тусдаа хэсэг болгон үзэж байна.

Хуучин социалист тогтолцоо задран унаж, хүйтэн дайн төгсгөл болж, онцгой хүчирхэг байсан их гүрэн ЗХУ задран унаснаар Европт ихээхэн улс төрийн өөрчлөлтийг дагуулан ирсэн. Берлиний хана нурж унаснаар хоёр Герман улс нэгдэн нэг улс болж, НАТО өөрийн хүрээгээ тэлж эхэлсэн, Европын Холбооны бүрэлдэхүүнд багтах гэсэн улс орнууд ихээхэн нэмэгдсэн зэрэг онцгой өөрчлөлтүүд гарах болсон билээ.

Харин Ази тивд хоёр Солонгос улсыг хуваасан 38-р өргөрөгийн дагуух “хуваагдлын” шугам өнөөдөр хүртэл хадгалагдсаар, дэлхийн олон нийтийг эмзэглүүлсээр байна. Дэлхий дахин хуваагдмал, хурцадмал хэвээрээ байгаагийн хамгийн тод илэрхийлэл бол Солонгос улсыг хуваасан энэ шугам болсоор байна.

XX-XXI зууны зааг дээр дэлхий дахинд гарсан өөрчлөлтийн зарим эерэг үр дүнд хоёр Солонгос улс эв нэгдлийн замд буцан орох болж, 2000 оноос төрийн тэргүүнүүдийн түвшинд хамтарсан тунхаглал байгуулж, 2006 оны намар хамтран хөгжих тухай 8 зүйлт мөрийн хөтөлбөрт гарын үсэг зурсан явдал бол дэлхий дахины хуваагдлыг даван туулах, Азид болон дэлхий дахинд энх тайвныг хадгалахад онцгой ач холбогдолтой түүхэн үйл явц болсон юм.

\* Н.Сарантуяа - Бие даасан хөгжлийн төлөө “Пэктусан” нийгэмлэгийн удирдах зөвлөлийн гишүүн, доктор (Ph.D)

Гэвч хоёр Солонгос улсын хуваагдлыг даван туулах энэ түүхэн үйл явцад дэлхийн их гүрнүүдийн оролцоо, тэдний ашиг сонирхолоо хамгаалах хуучинсаг байр суурь хүчтэй нөлөө үзүүлсэн хэвээр байна.

Энэ нэгдмэл улсын түүхэн хуваагдмал байдал чухам хэзээнээс үүдэлтэй, яагаад өнөөдрийг хүртэл хадгалагдсаар байгааг өнөөдөр дэлхийн олон нийт бараг мартаж тийш хандаж байна. Энэ хугацаанд нэгэн 60 өнгөрөн одож, хуваагдлын нөхцөлд төрж өссөн шинэ үеийнхэн нэгдмэл солонгос үндэстэн байсныг мартаж эхэлжээ.

XX зуун бол дэлхийн их гүрнүүдийн хоорондох том дайныг өдөөсөн онцгой зуун болж түүхэнд үлдсэн билээ. Дайн бол олз ашгийн төлөө улс орнуудын өрсөлдөөн байсаар ирсэн хийгээд дайны дараахи үйл явц бол дайнд ялсан, ялагдсан талуудын ололт, ашгийг хуваасныг баталгажуулах дүн, дүгнэлт болж өрнөдөг байна.

Хүчээр түрий барих улс төрийн бодлого бол их гүрнүүдийн улс төрийн бодлогын зарчим байсаар бүхий л XX зууныг дамжин ирсэн бөгөөд шинэ ХХI зууны эхэнд даяаршил, хамтын ажиллагааны тухай ихээхэн ярих болсон нөхцөлд ч энэ бодлогын үр хөврөл хадгалагдсан хэвээр байна. Гэтэл шинэ зуун бол дэлхийн нийт улс орны ард түмний хувьд тэгш хөгжлийн боломжийг нээх шинэ эрин мөн, энэ шинэ эринд улс түмний тэгш хөгжил, бие даасан байдал түгээмэл шинж чанартай болж өрнөх хэтийн боломж харагдаж байгаа юм. Жижиг буюу хөгжиж байгаа улс орнууд их гүрнүүдийн шийдвэрийг үг дуугүй хүлээн зөвшөөрөхөөс улам бүр татгалзах болно, өөрийн бие даасан байдал, тусгаар тогтнолын боломжуудыг нээхийн төлөө, тэгш хамтран хөгжихийн төлөө шургуу ажиллах болно гэдгийг түүхэн үйл явц урьдчилан харуулж байна.

Өнгөрсөн ХХ зуун бол дэлхий дахинд гутамшиг байж ирсэн колонийн тогтолцоо задран унасан эрх чөлөөний үйл явц, томоохон хувьсгал, нийгмийн дэвшлийн, шинжлэх ухаан техник, технологийн дэвшлийн эрин болон түүхэнд үлдсэн билээ. Дэлхийн улс орнуудад өрнөсөн эрх чөлөөний төлөө тэмцэл, хувьсгалт үйл явцын үр дүнд колонийн системийн задрал, дэлхийн улс төрийн бодлогын шинэ өөрчлөлтөд хүргэсэн, мөн ангийн тэмцлийг онцолсон суурин дээр хэт үзэл сурталжсан хуучин үзэл суртлаас ангижирсан, их гүрнүүд ба хөгжиж байгаа орнуудын тэгш харилцааны суурийг тавьсан зэрэг их өөрчлөлтийг дагуулан ирсэн юм.

Дэлхийн хоёрдугаар дайны дараа энэ дайны үр дүнг тооцох, ялагдсан талууд бууж өгөх хэлэлцээрт гарын үсэг зурах үе эхлэхэд тэр үеийн цэрэгжсэн империалист гүрнүүдийн бодлого улам бүр түрэмгий шинжийг агуулах болсон билээ. Дэлхийг хуваан эзэмших,

дахин хуваан эзэмших бодлого улам бүр ээдрээтэй хэлбэрт шилжих болсны нэгэн тусгал бол дэлхийн хэд хэдэн газар хуваагдлын бүсүүд буй болсон явдал мөн юм. Үүний дотор, Азийн улс орнуудыг, ялангуяа Солонгос улсыг хуваан эзэмших бодлого өнөөдрийг хүртэл үргэлжилсээр байгаа нь дэлхий дахинд дайны аюул заналыг хадгалах нэгэн суваг болж хадгалагдсаар байна. Дэлхийн хоёрдугаар дайны дараа их гүрнүүд дайнаас олсон олз ашгаа бататган авч, Ази ба Европт эзэмших газар нутгийн, байгалийн нөөц, хүн амын нөөцийг хуваах асуудлыг баталгаажуулахдаа жижиг орнуудын хувь заяаг өөрийн дураар шийдвэрлэн, зуун зууны туршид нэгдмэл байсан үндэстэн, улс орнуудыг хуваан авч, тэдгээрийн хооронд дайн самуун дэгдээн бутаргаж, “хуваагдал”, дайсгалын шугамыг буй болгосон нь түүхэн үнэн билээ.

Дайныг өдөөсөн, цэрэгжсэн улс орнууд тэр үеийн үзэл суртлын дайсгал, хуваагдлыг өдөөн ашиглаж, дэлхийн улс орнуудыг хуваан эзэмших бодлогыг бүх аргаар хэрэгжүүлсэн байна. Дэлхийн хоёрдугаар дайны эцэст ялагч тал буюу хуучин ЗХУ-тай холбоотон болж дайнд оролцсон АНУ энэ дайны эцсийн үр дүнг хуваах үйл явцад идэвхитэй оролцож, ингэхдээ дайнд ялагдсан Японы армийн зэвсгийг хураах үйл явцыг Солонгосын хойг дээр шийдвэрлэх санаачлага тунхаглан хэрэгжүүлэхдээ дайнд оролцсон бус, харин дайны хөлд нэрвэгдсэн солонгосын ард түмнийг хуваагдал, уналтын зам руу түлхсэн гол хүчин болсон байна. Үүнээс хэдхэн жилийн дараа, 5000 жилийн түүхтэй нэгдмэл Солонгосыг 1950-1953 оны ах дүүсийн хооронд цус урсгасан дайн руу турхиран түлхсэн болохыг өнөөгийн түүхчид өрөөстөлөөр гуйвуулан, хуучин ЗХУ ба БНАСАУ хамтран “коммунизмын далбаан дор” дайн эхлэн өдөөсөн мэтээр тайлбарласаар байна.

Дэлхийн хоёрдугаар дайны үр дүнд зэвсгийн наймааны ачаар баяжин бэхэжсэн АНУ асар их хөнөөлтэй, үй олноор устгах цөмийн зэвсэг бүтээж өөрийн их гүрнийг “ялагдашгүй хүчирхэг” болсныг харуулах зорилгоор дайнд ялагдсан Японы хотууд дээр энэ зэвсгээ туршин үзсэний үр дүнд дэлхийн улс төрийн тавцанд зэвсэглэлээр хөөцөлдөх, дайн өдөөж улс төрийн асуудлыг шийдвэрлэх зам руу өөрийн улсыг төдийгүй бусад улс орныг татан оруулж, олон жилийн турш үргэлжилсэн хүйтэн дайн руу татан оруулсан явдал түүхэн үнэн юм.

Үй олноор хөнөөх атомын зэвсэгт нэрвэгдсэн Японы ард түмэн дайн, зэвсэглэлийг эсэргүүцэн энэ 60 гаруй жилийн турш энх тайвны төлөө шургуу тэмцсээр ирсэн, харин түүхийн сургамжийг мартсан эрх баригчид нь өөрсдийгөө хөнөөсөн АНУ-ын эрх баригчдын

атомын зэвсэг, цөмийн бодлогын халхавчин дор нуугдах болсон нь түүхийн хошигнол мэт болохыг судлаачид олон удаа өгүүлж ирсэн.

Орчин үеийн дайнд дэлхий дахиныг нэг удаа бүрмөсөн устгах зэвсгийн бололцоо бүрдсэн, ийм нөхцөлд орчин үеийн дайны ойлголт үндсээрээ өөрчлөгдөх болсон байна. Гэвч ямар ч хөнөөлтэй зэвсэг бүтээн хэрэглэсэн ч дайны стратегийн бодлого, үзэл санааны ялалт орчин үеийн дайнд онцгой нөлөөтэй болж ирснийг стратеги судлаачид дүгнэж байна. 1950-1953 оны Солонгосын дайн бол америкчуудын өөрсдийн дүгнэснээр “цагаа олоогүй, газраа олоогүй, дайснаа зөв тодорхойлоогүй утгагүй дайн” болсон юм. 1970-аад оны Вьетнамын дайн, 2000-аад оны Иракийн дайн ч мөн адил юм. Ямар ч техникжсэн зэвсэг, технологи, зэр зэвсгийн хамгийн орчин үеийн шийдлүүдээс илүү өөрийн орныг, үндэстнийг ойлгон ухаарах гүн ухаан, түүхэн ойлгоц, улс төр-стратегийн ойлгоц нь дайныг хөтлөх явцад давуу ач холбогдолтой болсныг зарим судлаачид дүгнэсэн нь бодит түүхэн үйл явцад нийцэж байна.<sup>2</sup>

Хуучин ЗХУ болон Европын орнуудад социалист тогтолцоо задран унаснаар хүйтэн дайны төгсгөл эхэлсэн, харин өнөөдөр социалист тогтолцоо бол дайн өдөөгч үзэл сурталжсан, дайсгалын тогтолцоо мөн гэх дүгнэлт ихээхэн газар авсан байна. Солонгосын хойг дахь дайны аюул занал хадгалагдсаар байгаа болон хоёр Солонгос улс нэгдэж чадахгүй өнө удаан он жилүүдийг элээсээр байгаа явдлыг БНАСАУ дахь социалист тогтолцоотой холбон тайлбарлах явдал байсаар байна. Хоёр Солонгосыг хувааж байгаа шугам нь нэгэн утгаараа Умард Солонгост социалист тогтолцоо ихээхэн тогтвортой байгааг илтгэж байгаа нь үнэн юм. Иймд социализмын тухай асуудалд нэгэн анхаарлаа хандуулах хэрэгтэй болж байна.

Хуучин ЗХУ болон Европын орнуудад, мөн Монгол оронд нийгмийн өөрчлөлтийн туршилтын үндэс болсон социалист үзэл суртал бол нэг ангийн ноёрхлыг диктатурын хэлбэрээр онцгой болгон үзсэн, ангийн тэмцлийг онцолсон, ангич намч үзэл суртлаар дарангуйлах дайсгалын нийгмийн тогтолцооны нэг хэлбэр байсан гэж энэ туршилтыг дүгнэн өгүүлж болно. Ангийн диктатурыг хүлээн зөвшөөрөхөөс өөр хувилбаргүй, нэг анги нь нийгмийн бусад анги бүлгийг дарангуйлах эрхтэй тогтолцоо хэрэгжиж байсан юм. Энэ бол марксизмын бүтээлч хэлбэр болж хөгжсөн, хуучин Коминтерны хүлээн зөвшөөрөн хэрэгжүүлсэн ангийн тэмцлийн хурц үзэл суртал болох ленинизмын хувилбар хэрэгжсэн явдал байсан билээ. Энэ

бол туйлшрал, шугаман диалектикийг онцолсон Европын нийгмийн сэтгэлгээний сонгодог жишээ мөн юм.

Өнөөгийн шинэ эрин үед социализмын түүхэн хувилбарууд хадгалагдсаар байна. Азийн социализм, үүнд Хятад, Вьетнам, Лаос, БНАСАУ зэрэг орнууд багтах, Латин Америкийн социализм байна, тухайлбал, Куба, Венесуэль, мөн “хөгшин” Европт өөрт нь хүртэл социализмын түүхэн загвар хадгалагдсаар байна. Азийн социализмын түүхэн хувилбарууд өөр өөрийн эдийн засгийн өвөрмөц суурьтай юм: зах зээлийн эдийн засгийн суурьтай социализмыг Азийн ихэнхи орнууд сонгосон бол БНАСАУ эдийн засгийн төрийн төвлөрсөн бааз суурийг зарим улгаар хадгалсан хэвээр байгаа юм.

Европ болон Америк тивд үндэстэн дамнасан корпорациуд ард түмний үндэсний бүтээмж болон баялгийн ихэнхи хувийг гартаа эзэмшин барьж ирсэн уламжлалтай бол Азид социализм, капитализм ямар ч хэв загвартай байж ирсэн ард түмний эрх ашиг, нийт үндэстний эрх ашигт үйлчлэх нь илүү давуу байгааг тэмдэглэх хэрэгтэй юм.

Ази дахь социалист тогтолцоо өнөөг хүртэл харьцангуй тогтвортой, өөрийн хөгжлийн нөөцтэй, олон хувилбартай байж ирэв. Хамгийн тогтвортой социалист тогтолцоотой улс орон бол БНАСАУ болж байна. Социалист систем задран унасны дараа, социалист зах зээл үгүй болон утсанаар энэ орны хувьд хүнд бэрх эдийн засгийн бэрхшээл тулгарч ирсэн, мөн үүний дээр их гүрнүүдийн эдийн засгийн зориудын хавчилтад өртөх болсон ч 20 сая гаруй солонгосчууд сонгож авсан өөрийн амьдрал, замаасаа нэг ч алхам ухарсангүй.

Хоёр Солонгосыг хуваасан “хуваагдлын” шугамыг түүхийн тавцангаас арилган устгахын тулд БНАСАУ-д социализмаас ухрах замыг тулган хүлээлгэхийг өнөөдөр ч их гүрнүүд оролдсоор байна. Харин энэ “хуваагдалын” шугам бол Солонгос дахь социализмын тогтвортой байдлын бэлгэдэл мөн байхаасаа илүү их гүрнүүдийн зүгээс улс түмний хувь заяаг өөрийн дураар шийдвэрлэхэд түлхсээр ирснийг гэрчилсэн эмгэнэлт түүхийн бэлгэ тэмдэг болж хадгалагдсаар байна.

Өнгөрсөн зууныг дамжин энэтхэгчүүдийг колоничлон суусан англичуудыг энэтхэгчүүд эсэргүүцэхдээ “үл хүчирхийлэх” зарчмыг баримталсан ч эрх чөлөөний төлөө тэмцлээ байнгын, тасралтгүй, ухрахгүй эсэргүүцлийн хэлбэрээр үргэлжлүүлэх арга замаар явуулсан билээ. Харин түүхэн өөр нөхцөлд улс орныхоо хуваагдлыг эсэргүүцсэн өмнөд ба умард хэсгийн солонгосчуудын эсэргүүцлийн замнал өөрийн ёс зүйтэй байх буюу хуваагдлыг сөрөн зогсох ёс зүйгээр илэрч байна.

БНАСАУ өөрийн түүхийн турш гадны дарангуйлал оролцоог эсэргүүцэхдээ үндэстэн, төр улс, ард түмэн өөрөө батжин бие дааж орших тухай “жүчэ” үзэл санааг бүтээн боловсруулж, өнөөдөр энэ үзэл суртлын хүчээр Азийн аль ч улс оронд байхгүй батлан хамгаалах их хүчин чадлыг буй болгожээ. Солонгосын хойг дахь социалист тогтолцоо энэ үзэл суртлын суурь хүчинд тогтвортой, хүчтэй хэвээр хадгалагдсаар байна. Нэг ёсондоо өөрөө батжин бие дааж орших тухай үндэсний үзлийг өөрийн өвөрмөц социализмын суурь болгон хөгжүүлсэнд БНАСАУ дахь онцгой өвөрмөц нийгмийн чанар оршиж байгаа юм.

Иймд хоёр Солонгос улсад байгаа нийгэм-үзэл суртлын тогтолцооны ялгааг даван туулахад тийм ч бэрх бус юм, учир нь “жүчэ” үзэл санаа бол солонгосын үндэсний үзэл санаа мөн юм, үүний дээр хөгжлийн хамтарсан хөтөлбөрийг сонгон хэрэгжүүлэх явцад хоёр тал бие биесээ ойлгох бүрэн боломж байгааг 2000 оноос хойшхи үйл явц нэг бус удаа харуулсан билээ. Энд судлаачийн хувьд дүгнэн хэлэхэд БНАСАУ дахь төрийн үзэл суртал болсон “жүчэ” үзэл санаа бол өөрийн оронд харийг халдаахгүй, өөрөө батжин орших тухай солонгосчуудын уламжлалт гүн ухаан XX зууны шинэ түүхийн нөхцөлд хөгжсөн шинэ хувилбар мөн болохыг онцлон хэлэхийг хүсч байна. Энэ үзэл санаа бол солонгосчуудад төдийгүй, дэлхийн улс түмэнд ойлгомжгүй үзэл санаа бус юм. Иймд хоёр Солонгос орны ард түмэн үзэл суртлаасаа хамааран бие биесээ үл ойлголцох үндэс үгүй гэж дүгнэж байна.

Гэвч Солонгосын “хуваагдлын” шугам хадгалагдсаар байна. Энэ бол их гүрнүүдийн эрээ цээргүй оролцооны үр дагавар мөн болохыг нотлон дүгнэхэд хүргэж байна. Өнөөдөр Солонгосын хойг дээр 43 мянга орчим америкийн цэрэг байсаар байгаа нь хоёр орны эв нэгдэлд садаа болсон, аюулгүй байдалд нь заналхийлсэн үндсэн хүчин зүйл мөн болохын зэрэгцээ Ази дахь энх тайван, дэлхий дахины энх тайванд аюул занал болсоор байна.

Харин дэлхийн их гүрнүүдийн бодлого, тэдгээрийн тэнцвэрт байдалд дэлхийн хоёрдугаар дайны эцэст ихээхэн өөрчлөлт гарсны дараа шууд, илэрхий мөлжлөг, дарлалаас ангид, өөр далд аргаар буюу хөгжлийн бодлогыг зангидан барих аргаар шинэ их гүрнүүд бусад улс түмэнд өөрийн хяналтаа тогтоох болсон байна. Хөгжлийн бодлогын хяналтыг гартаа барих нь санхүү-эдийн засгийн давуу боломжийг эдгээр цөөн тооны их гүрнүүдэд олгож байгаа бөгөөд эдгээр их гүрнүүд өөрийн улс төрийн болон судалгааны байгууллагуудын тусламжтайгаар энэ хяналтаа барьсан хэвээр байна.

Хамтран хөгжих бололцоог өөртөө нээхийн тулд хоёр Солонгосын удирдагчид болон ард түмэн их гүрнүүдийн эрхийг сөрсөн хатуу тэмцэл хийх, оюун ухааныхаа чадварыг ихээхэн дайчлах хэрэгтэй болсон нь түүхэн шинэ нөхцөлд улам бүр тодорхой болов.

Шинэ эрин зуунд аль ч ард түмэн, үндэстэн өөрөө өөрийн хувь заяаг бие даан шийдвэрлэх, тэгш эрхтэй хөгжлийн болоцоог хэрэгжүүлэх дэлхийн улс түмэнд нийтлэг, түгээмэл эрхийг тунхаглаж байна. Гэвч хөгжиж байгаа орнуудын эдийн засгийг боомилох, хөгжлийн бодлогыг зааж зааварлах давуу эрхийг барьсан их гүрнүүдийн бодлогод дасан уусаж, эдийн засгийн хараат байдлаас улс төрийн хараат байдалд шилжих осол дагуулсан үе үргэлжилсээр байна.

Ийм шинэ нөхцөлд эдийн засгийн хувьд хараат бус болох, улс төрийн бие даасан бодлого явуулах, үүний тулд өөрөө өөрийгөө батлан хамгаалах улсын чадавхийг бэхжүүлэх, эдгээрийн суурь үндэс бол өөрийн үндэстэн, ард түмний эрх ашигт нийцсэн үндэсний үзэл сурталтай байх явдлыг заасанд “жүчэ” үзэл санааны үндсэн агуулга оршиж байгаа юм.

Өнөөгийн их гүрнүүдийн оролцоо даяаршлын далбаан дор хэрэгжиж байна. Холбоо харилцаа, мэдээллийн технологи дэлхийн нийтийн амьдралд онцгой нөлөөлөх хүчин зүйл болсон нь даяаршилын үйл явцыг гүнзгийрүүлж байгаа боловч даяаршил бол үндсэн утгаараа их гүрнүүдийн улс төрийн бодлого мөн байна. Ийм ч учир даяаршлын улс төрийн мөн чанарыг эсэргүүцсэн хөдөлгөөн дэлхий даяар улам бүр хүчээ авах болов.

АНУ-аас өнөө үед дэлхийг удирдаж байгаа даяаршил бол барууны ертөнцөд багтдаггүй Ази, Африк, Ойрхи Дорнодын улс орнуудыг дэлхийн хөдөлмөрийн хуваарь болон нөөцийн хуваарилалтад татан оролцуулах шинэ колоничлолын бодлого мөн болохыг олон эрдэмтэд анхааруулан сануулсаар байна. Тэгш бус хэмтэй интеграцийн бодлогод татан оролцуулахдаа Олон Улсын Валютын Сан болон Олон улсын Сэргээн босголт, Хөгжлийн Товчооны удирдлага заавраар макро эдийн засгийг тогтворжуулах, эдийн засгаа нээлттэй байлгах арга хэмжээнүүдийг авч, үндэстэн дамнасан корпораци ба банкуудад өөрийн хил хязгаараа нээхийг хөгжиж байгаа орнуудад зааж байгаа юм. Харин хөгжиж байгаа орнуудын нийгэм-үйлдвэрлэлийн бүтцийг үндсээр нь шинэчлэх, ингэснээр эдгээр орныг хөгжлийг зарчмын шинэ түвшинд гаргах бодлого огт үгүй байгааг дүгнэсэн байна.<sup>3</sup>

Их гүрнүүдийн улс төрийн бодлогын оролцоо хөгжлийн бодлогын оролцоогоор солигдох болов. Ийм нөхцөлд өөрийн оюун санааны хүчин чадлыг онцгой ашиглах чадвартай, эв нэгдэлтэй ард түмэн бусдаас хараат бус эрх чөлөөтэй, жинхэнэ хөгжлийн замд гарч бодитой хөгжих бололцоогоо олж авч чадах билээ.

Хоёр Солонгос улсыг холбосон бөгөөд заагласан “хуваагдлын шугам” Солонгос дотор өөрт нь байгаа үзэл суртлын, нийгмийн дэглэмийн ялгаанаас үүдсэн мэт тайлбарлах нь бодит үйл явцыг хуурамч хөшигөөр халхлах, хуурамч арга зам мөн болохыг ойлгох боломжийг шинэ түүхэн үйл явдлууд нээж өгөв.

Их гүрнүүдийн бодлогын оролцоо Ази тивд өнөөг хүртэл онцгой нөлөөтэй хэвээр байгаагийн үр дүнд Солонгосын “хуваагдлын шугам” байсаар, энэ нөхцөлд хамтран хөгжих эрхээ хамтран тунхаглаж байгаа солонгос үндэстнийг хуваагдсан хэвээр байлгах сонирхол их гүрний бодлогын сонирхол мөн болох нь улам бүр илэрхий болов. Үүний бэлэн нотолгоо бол Солонгосын хойгоос цэрэг-улс төрийн нөлөөгөө салгахгүй байгаа АНУ-ын бодлого, тэдний энд байрласаар байгаа цэргийн баазууд мөн юм.

Их гүрнүүд энэхүү цэргийн оролцоо, нөлөөгөө энхийг сахиулах бодлогоор тайлбарладаг. Мөн хөгжиж байгаа орнуудын дотоод хэрэгт оролцох аливаа улс төрийн оролцоогоо тайлбарлахдаа “тоталитар дэглэмийг унагах”, “ардчилсан өөрчлөлтийг дэмжих”, “хүн төрөлхтөний нийтлэг үнэт зүйлсийг тогтоох” гэх мэт нэр хаяг хэрэглэдэг, эдгээр нь үзэл суртлын оролцоогоор урьдчилсан бэлтгэл хийж байгааг нотлон харуулж байна.

Харин бодит үйл явц дээрхээс яг эсрэг агуулгатай буюу түрэмгий дайныг өдөөсөн, даамжруулсан, үй олон хүнийг хөнөөсөн дайныг үргэлжлүүлсэн их гүрний бодлого болж хувирдагийг Ойрхи Дорнодод болсон үйл явдлаас дэлхийн олон нийт тодорхой харсан билээ.

Дэлхий дахинд хуваагдлын сөрөг хүчин зүйл бодитой хадгалагдсаар байгааг хоёр Солонгосын “хуваагдлын шугам” гэрчилж энэ хуваагдлын шугамын дагуу шинэ дайны аюул Азид ямагт хадгалсаар ирэв. Солонгосын хойгт хоёр дахь удаагаа “Солонгосын” дайныг өдөөх сонирхол их гүрнүүдэд өнөөдөр ч байсаар байна. Харин энэ түүхэн нөхцөлд зэвсгийн хүчээр асуудлыг зохицуулах гэж оролдвол аль ч талд нь сүйрэл дагуулж ирэх нь тодорхой юм.

Орчин үеийн хурц сөргөлдөөнийг зөвхөн оюун ухааны хүчээр л шийдэж зохицуулах боломж байгаа билээ. Ингэхдээ өөрийн үндэстнийг ухаарах гүн ухаан, үзэл санааны итгэл үнэмшил, мэдлэг



чадвар, оюуны нөөц шийдвэрлэх ач холбогдолтой зэвсэг болж хувирч байна

Иймд Умард ба Өмнөд Солонгост байгаа нийт ард, иргэд, эх орон нэгтнүүд хамтран өөрийгөө, үндэстнээ дахин ухаарах гүн ухааны үндэсний суурийг бэлтгэх нь түүхэн турш хуримтлагдсан ээдрээтэй олон асуудлыг шийдвэрлэн зохицуулахад ямар ч зэвсгээс илүү үр нөлөөтэй байж болох юм гэж үзэж байна.

Өмнөд Солонгост тогтсон нийгмийн байгуулал нь үндсэндээ барууны загвартай бөгөөд Ази тивд багтан оршиж байгаа Япон хийгээд Өмнөд Солонгосыг Азийн баруунжсан улсууд хэмээн судлаачид тодорхойлж байна.

Азийн орны уламжлал, сэтгэлгээ, түүхээсээ чухам юуг нь авч үлдсэн бэ гэсэн асуулт тавибал, Японоос илүү үндэсний уламжлал, сэтгэлгээгээ гэсэн улс бол Өмнөд Солонгосчууд болж байна. Хэдийгээр шинжлэх ухааны дэвшил, техник технологийн дэвшил Өмнөд Солонгосын нийгмийн хөгжил, өөрчлөлтийн давуу тал болсоор байгаа ч үндэстнээ ухаарах сэтгэлгээ хомсдсон, үндэсний соёл, ёс суртахуун нь гадны нөлөөгөөр устаж эхэлсэн гэж үзэж болох мэт санагдаж байна.

Тэгвэл цаашдын нэгдмэл Солонгосын хувь заяаг шийдвэрлэхэд энэ үндэсний ухаарал, түүхэн ухаарал, гүн ухаан, ёс суртахуун нь онцгой ач холбогдолтой байх төлөв харагдаж байна.

Орчин үеийн дайн энхийн асуудлыг улс түмний оюун санааны хүчин зүйлээр шийдвэрлэх хандлага руу түүхэн үйл явц өрнөж байна. Ямарваа хуваагдлын шугамгүй нэгдмэл үндэстнээ дахин сэргээхэд Солонгос орны удирдагчдын оюун санааны нөөц чадвар, ард түмнийх нь оюун санааны нөөц энэ түүхэн шинэ нөхцөлд тэргүүн шугамын, үндсэн, шийдвэрлэх нөөц болох үйл явцыг бид урьдчилан харж байна. Ийм нөөцгүйгээр солонгос үндэстэн өөрийн хүчээр бие даан улс орноо нэгтгэх, хамтран хөгжих бололцоогоо нээх боломжгүй болох нь тодорхой байна.

Бие дааж орших, бие дааж хөгжих тухай солонгос үндэстний үзэл санааны суурь бол үндэсний сэтгэлгээ, гүн ухааны суурь нөөц нь мөн юм. Ямар ч үндэстэнд ийм нөөц хэрэв байвал, эдийн засгийн чадавхи бага байсан ч, өөрийгөө батлан хамгаалах нөөцгүй байсан ч өөрийн үзэл санааны, улс төрийн бодлогоо зөв тодорхойлон явах оюун санааны давуу талыг ямагт олгох нь зүй ёс мөн юм.

Нэг үндэстэн хоёр улс болон хуваагдаж, нэгэн жарныг туулж байгаа эмгэнэлт түүхийг эцэс болгох, энэ түүхэн уршгийг

тарьсан империализмын жинхэнэ нүүр царайг илчлэн түүнийг түүхийн тавцангаас арилгах явдал нийт шинээр бие даасан эрхээ олж авсан улс түмний нэгдмэл нэгэн зорилго болж байгаа юм. Одоогоор хоёр өөр үзэл санаа, улс төр, нийгмийн тогтолцоотой өөр өөр үнэлэмж, үнэт зүйлсийг эрхэмлэдэг болсон нэг үндэстэн энэхүү ялгаатай үнэлэмжээ нэгдмэл үнэлэмж болгон өөрчилж, сэтгэлгээний хүрээнд хувьсгал хийх нь өөрийн үндэстнийг дахин ухаарал гүн ухааны шинэ ухаарлаас ихээхэн хамаарах юм.

Ийм ухаарлыг нийт солонгос үндэстэнд аугаа их Ким Ир Сен залгамжлуулан үлдээжээ. Солонгосын Холбооны Бүгд Найрамдах Улсыг байгуулах тухай Ким Ир Сений үзэл санаа нь онолын шинэ бүтээлч бөгөөд ардчилсан шийдлийн үлгэр жишээ болсон хэмээн дэлхийн олон нийт үнэлж байна. Аугаа их жолоодогч Ким Ир Сен улс орноо хуваагдмал байдалд орсон анхны өдрөөс эхлэн нэг Солонгосын тухай чиг шугамыг баримталж, эх орноо нэгтгэхэд чиглэсэн 3 зүйлт зарчим, нийт үндэстний их нэгдэл нягтралын төлөө 10 зүйлт мөрийн хөтөлбөр, Холбооны Бүгд Найрамдах Корё Улсыг байгуулах тухай саналыг дэвшүүлсэн байна.

Бие даах, энх тайвнаар нэгтгэх, үндэстний их нэгдэл нягтралыг хэрэгжүүлэх гэсэн 3 зүйлт зарчим нь Солонгосыг нэгтгэх асуудлыг үндэстний үзэл бодол, эрх ашигт нийцүүлэн үндэстний өөрийн хүчээр шийдвэрлэж болох үндсэн байр суурь болон арга замыг тодорхойлсон Солонгосын нэгдлийн үндэс суурь болж байна. Энэ зарчим бол Солонгосын Умард, Өмнөд хоёр 1972 оны 7-р сарын 4-нд хамтарсан мэдэгдлийг нийтлүүлэн нотолж, гадаад дотоодод тунхагласан үндэстний нийтийн мөрийн хөтөлбөр юм.

1980 оны 10-р сард Холбооны Бүгд Найрамдах Ардчилсан Корё Улсыг байгуулах тухай саналыг гаргасан нь Солонгосын нэгдмэл төрийн дүр төрх, үүнийг хэрэгжүүлэх арга замыг тодорхойлсон төсөл болсон байна. Энэ саналд Умард, Өмнөд хоёр тус тусын үзэл санаа, нийгмийн байгууллыг харилцан хүлээн зөвшөөрсөн үндсэн дээр улс орноо шударгаар, саадгүй нэгтгэх үйл явцыг хэрэгжүүлж болох үндсэн арга барилыг тодорхойлсон байна.

Улс орны Умард ба Өмнөд нийгмийн өөр өөр үзэл бодол, нийгмийн байгуулал урт удаан хугацаанд тогтож ирсэн Солонгосын бодит байдалд зохицуулсны дээр нэгдлийг хүсэн мөрөөдөж буй нийт үндэстний хүсэл эрмэлзэлд нийцүүлэн улс орноо нэгтгэж болох зөв зүйтэй, оновчтой арга замыг энэхүү 3 зүйлт дүрэмд тодорхой заасан байна.

Улс орноо хуваагдсанаас хойш 55 жилийн дараа анх удаа Умард, Өмнөдийн төрийн тэргүүн нарын уулзалт болж, эх орноо

нэгтгэх чиглэл болох 2000 оны 6-р сарын 15-ны хамтарсан тунхаглал нийтлэгдсэн явдал бол өнөөгийн Солонгосын удирдагч Ким Чен Ир-ийн уйгагүй хүчин чармайлтын үр дүн мөн юм. “Манай үндэстний хүчээр” гэсэн уриаг эх орноо нэгтгэх нийт үндэстний эрхэм дээд зорилго болгон дэвшүүлсэн явдал бол эх орноо нэгтгэх үйл хэрэгт түүний оруулсан гавъяа мөн юм.

2000-2005 оны эхний таван жилийн хугацаанд Умард, Өмнөдийн эрх баригчдын хооронд сайдын хэмжээний уулзалт 14 удаа, эдийн засгийн хамтын ажиллагааг түргэтгэх хорооны хурал болон ажил хэргийн уулзалт 42 удаа, цэргийн эрх баригчдын уулзалт 11 удаа, нийт 100 гаруй уулзалт яриа явагдсан байна. Мөн Улаан Загалмайн Нийгэмлэгийн хэлэлцээний үр дүнд салж сарнисан гэр бүл, төрөл төрөгсдийн уулзалтыг 10 удаа зохион байгуулжээ. Мөн олон байгууллага, нийгэмлэгүүдийн, нийгмийн олон давхаргуудын уулзалтыг зохион байгуулжээ. Тасарсан төмөр зам, авто замыг холбож, хүмүүс энэ замаар олон удаа зорчиж, харилцан аялал жуулчлалыг зохион байгуулсан байна.

2007 оны намар Умард ба Өмнөд Солонгос улс хамтран хөгжих тухай 8 зүйлт мөрийн хөтөлбөрт хамтран гарын үсэг зурж, хэрэгжүүлэх ажлаа эхлүүлжээ.

Солонгосын ард түмэн, үндэстэнд нэгдлийн халуун салхи авчирсан Ким Чен Ир жанжин хүчирхэг улс гүрнийг байгуулах, эх орноо нэгтгэх үйл хэрэгт “сонгун” улс төрийн бодлогын тугийг өндөрт өргөн, гадны оролцоо, дайн хуваагдлыг мөнхжүүлэх гэсэн өдөөн хатгалгаас нийт үндэстнийхээ хувь заяаг хамгаалж, Солонгосын хойгийн энх тайван, аюулгүй байдлыг хамгаалсан бөгөөд эх орон нэгтнүүдийнхээ эвлэрэл, хамтын ажиллагааны үйл хэргийг манлайлан удирдаж байна.

### ЭШЛЭЛ, ЗҮҮЛТ

1. Сергей Карагаев. “Дор хаяж гурван Ази байна...” өгүүлэл. “Өнөөдөр” сонин. 2008.7.29. №173
2. Ким Мен Чхор. Северная Корея, сценарий войны и мира. Пхеньян. 2001.
3. Рехман Собхан. “Даяаршил шинэ болон сэргээн тогтоосон ардчилалд нөлөөлөх нь”. Ардчиллыг шинээр болон сэргээн тогтоосон орнуудын 5-р бага хурал. УБ, 2003, И.Б.Орлова. Евразийская цивилизация. М, 1998. бүтээлийн удиртгал: “Как структурируется современный мир”